



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/61

Шивээговь сум

Гэр бүлийн хэрэгцээнд хамтран  
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын 2005 оны 59 тоот захирамжаар гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Шивээговь сумын 2 дугаар баг, Урсахын 10-03 тоотод байрлах 900 м<sup>2</sup> хэмжээтэй 1260000 төгрөгийн үнэ бүхий газрыг Харчу овогт Тавхайн Наранцэцэгт үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны А/11 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

4. Иргэн Жүгдэрийн Хаянхярваад хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

421200164